

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
(2024 оны жилийн эцсийн тайлан)**

2024.11.25

Шийдвэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар агуулга	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Чойр	
							Дээд шатны байгуу лын үнэлгээ	Үнэлгээн ий тайлбар
МУ-ын хууль:								
4	15	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах хэрэгжүүлнэ	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны ажлын төлөвлөгөөг 5 зорилт 15 арга хэмжээгээр боловсруулж баталсан ба хэрэгжилт 100% Гадаад, дотоод нийт 44 удаагийн сургалтад давхардсан тоогоор 336 албан хаагч, малын эмч нарыг хамруулж, мэргэжлийн болон эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн Байгууллагын 6 албан хаагчид нийт 1,500,000 төгрөгийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлсэн. Мөн Засгийн газрын 2024.02.28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор 4 албан хаагчид 28,360,809 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. Үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нөхөх төлбөр, урамшуулалт цалин зэргийг холбогдох хуулийн хүрээнд 14 албан хаагчид сар бүр олгосон. Томилгоот 1 албан хаагчийг байгууллагад бүртгэлтэй орон сууцанд, 1 албан хаагчийг Сүмбэр сумын ЗДТГ-ын дэмжлэгтэй түрээсийн байранд, 1 алба хаагчийг АЗДТГ-ын шийдвэрээр 1 өрөө түрээсийн байранд суулгаж амьдрах орон сууцны асуудлыг хамтран шийдвэрлэсэн. Байгууллагын 2 албан хаагчид нийт 6,600,000 төгрөгийн 2ш компьютерийг	100%		

					худалдан авалтаар нийлүүлж, ажиллах нөхцлийг сайжруулсан. Үр нөлөө:Томилгоот албан хаагчдын тогтвортой ажиллах нөхцлийг дотоодын нөөцөд тулгуурлан сайжруулсан.			
	17	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	Төрийн аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт цахим системд байршуулах.	Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3.9 сая төгрөгийн мөнгөн гүйлгээ бүхий зөрчил илэрч акт 2, зөвлөмж 1-ийг өгсөн ба зөрчлийг арилгасан. Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй дүгнэлт” авсан. Байгууллагын цахим хаягт байршуулсан. Үр нөлөө:Зөрчилгүй дүгнэгдсэн ба байгууллагын цахим хуудсанд байршуулж ил тод байдлыг хангасан.	100%		
7	19	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2021-12-24 Дугаар 2021-12-24	11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ. (11.2.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг сар бүр тайлагнах	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн сайжруулах шаардлагатай арга хэмжээ холбогдох заалт бүрээр сар бүр аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлж хэвшсэн. Үр нөлөө:Хяналтад авсан заалтын гүйцэтгэлийг сар бүр тайлагнаж, үр дүнг тооцож, сайжруулж ажилласан.	100%		

		асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.)							
УИХ-ын байнгын хорооны тогтоол									
23	57	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04 БОХХААБХ	1.4/. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох зорилгоор отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавигдах мал эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулах талаар онцгой арга хэмжээ авах, зарим эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн байнгын болон түр хяналтын цэгийг нэмэгдүүлж, мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийг сайжруулах;	Отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавигдах мал эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулах. зарим эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн байнгын болон түр хяналтын цэгийг нэмэгдүүлж, мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийг сайжруулах.	Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох зорилгоор отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавигдах мал эмнэлгийн хяналт, шалгалтыг зохион байгуулж тус арга хэмжээний хүрээнд мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн түр хяналтын цэгийг 2024.05.01-15-ний өдрүүдэд хөдөлгөөнт эргүүлийн хэлбэрээр ажиллуулах зэрэг арга хэмжээ авсан. Хяналт шалгалтаар Шивээговь сумын нутаг дэвсгэрт отроор ирсэн 4 малчин өрхийг нутаг чөлөөлүүлэх, мөн гоц халдварт өвчний голомттой бүс нутгаас мал эмнэлгийн гэрчилгээгүй хөдөлгөөн хийсэн Дундговь аймгийн Сайнцагаан сумын 1 малчин өрхийг Зөрчлийн тухай хуулийн 13.9.2 дахь заалтаар 50,000 төгрөгөөр торгож зөрчлийг дахин давтахгүй байх талаар зөвлөгөө, зөвлөмж өгч нутаг чөлөөлүүлэх арга хэмжээ авсан. Үр нөлөө:Мал, амьтны гоц халдварт өвчнөөр тайван статусыг хангасан.	100%			
	58		1.5/. Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах	Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг авч ажиллах.	Гоц халдварт хонины цэцэг, бог малын мялзангийн тандалт судалгааг 01 сарын 15-ны өдрөөс 6 удаа идэвхитэй ба идэвхигүй хэлбэрээр зохион байгуулсан. Тандалтанд эрсдэлтэй бүс нутгийн нийт 463 хот айлыг хамруулсан ба 168726 толгой мэдрэмтгий малд эрүүл мэндийн ерөнхий үзлэг хийсэн. Тандалтаар хонины цэцэг, бог малын мялзангийн сэжиг таамаг илрээгүй. Гоц халдварт 4 төрлийн өвчний эрт илрүүлгийн үзлэг, тандалтыг 6 МЭҮН сар бүр өөрийн гэрээт малчин өрхийн мэдрэмтгий	100%			

			хүртэл хариуцлага тооцох;		малд хийсэн ба 11 сарын 25-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 220 өрхийн 13799 толгой малд эрт илрүүлгийн үзлэг хийж, нийт 583 өрхийг МЭНС-д мэдээлсэн. Үүнд мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж, зөвлөмж арга зүйгээр хангаж ажилласан. Үр нөлөө:Гоц халдварт шүлхий, хонины цэцэг, богийн мялзан, үхрийн арьс товруутах өвчин тохиолдоогүй байна.			
	59		1.6/. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах	Малчдыг 2024 оны малын тоо, толгойн албан татвараас чөлөөлөх тухай шийдвэрийг Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын ИТХ-аас гаргасан.	-		
	60		1.7/. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах;	вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах;	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчин гарсан үеийн мал эмнэлгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр байгууллагын нөөцөд 25.3 сая төгрөгийн өртөг бүхий 540кг халдваргүйтгэлийн бодис, 950ш нэг удаагийн халдвар хамгааллын хувцас, 1200ш нэг удаагийн маск, 2500ш нүдний шил, 2100ш нэг удаагийн улавчны болон бусад нөөцийг бүрдүүлсэн. Үр нөлөө:Мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үеийн бэлэн байдлыг хангасан.	100%		
	67		1.1.12/. “Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд	Байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх. Хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж	Байгууллагын эцэг, эхийн зөвлөл 2024 онд хэрэгжүүлэх ажил арга хэмжээний төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжүүлсэн ажлын тайланг тогтоосон хугацаанд аймгийн гэр бүл хөгжлийн газарт хүргүүлж ажилласан. “Байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг	100%		

			Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж байгууллагуудад хүргүүлэх.	байгууллагуудад хүргүүлэх.	эхийн зөвлөл"-ийг чадвахжуулах сургалтад 3 удаа давхардсан тоогоор 8 албан хаагчийг хамруулсан. Сургалтаар олж авсан мэдээллээ тухай бүр албан хаагчдад танилцуулж мэдээллээр хангасан. Мөн "Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга" сэдэвт сургалтыг эцэг, эхийн зөвлөлөөс зохион байгуулж, албан хаагчдыг бүрэн хамруулсан. Үр нөлөө: Байгууллагын дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулсан. Хүүхэд хамгааллын бодлого боловсруулж баталж мөрдөж эхэлсэн. Албан хаагчдын хүүхэдтэй холбоотой бүхий л асуудлаар удирдлага, хамт олон ээлтэй шийдвэр гаргаж тухайн албан хаагчид дэмжлэг үзүүлж хэвшсэн.				
Ерөнхийлөгчийн зарлиг									
30	75	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Бүх шатны байгууллагын гадна, дотно хаягийг хос бичгээр бичих. Гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичих. Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, идэвх санаачилгыг дэмжиж, урамшуулах.	Байгууллагын гадна хаяг, дотор ажлын байрны хаягыг хос бичгээр бичиж байршуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 105 дугаар зарлиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Монгол бичгийн хэрэглээг олон нийтийн хүртээл болгож, хос бичигтэн болгох, үндэсний өв соёлоо хөгжүүлэх, "Үндэсний бичиг үсгийн баяр"-ын арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан Монгол Улсын гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит "Монгол бичиг мину-XXI" говийн бүсийн олимпиадад, Сүмбэр сумын ЗДТГ-аас зохион байгуулсан "Монгол бичигтэн 2025" тэмцээнд давхардсан тоогоор 11 албан хаагч амжилттай оролцсон. Үр нөлөө: Монгол бичгийн олимпиад болон бусад тэмцээнд 11 албан хаагч оролцож, мэдлэгээ сорьсон.	70%			

32	77	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах.	Орон нутгийн төсвийн нэг хувиас доошгүй хөрөнгийг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд зарцуулах “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Сум дундын Ойн ангиас 2019 онд “Хайлаас”, “Улиас” мод суулгасан 2017/01 дугаар бүхий нийтийн эзэмшлийн талбайг хариуцуулж өгсөн. Уг талбайд 2019 онд “Хайлаас” 25, “Шар хуайс” 7 ширхэгийг, 2020 онд “Хайлаас” 25 ширхэг, 2021 онд “Хайлаас” 37 ширхэг, 2022 онд 12 ширхэг “Хайлаас” нэмэлтээр тарьж, 14 хоног тутамд арчилгаа, тордолт, усалгаа хийж ажилласны үр дүнд 223 ширхэг мод бүрэн ургаж, ургалтын хувь (2021 онд аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн гаргасан дүн) 94.8%. Бүх нийтийн мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр байгууллагаас 60 ширхэг хайлаас, 10 дугаар сарын 10-ны өдөр 50 ширхэг модыг өөрсдийн нөөц бололцоог ашиглан Байгаль орчны газраас зааж өгсөн газарт тарьж, усалгаа хийсэн ба 2024 оны хавар, намрын тарилтаар нийт 110ш суулгац суулгасан. Үр нөлөө:Ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд оролцож нийт 230ш суулгацыг шинээр суулгасан.	100%		
34	83	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.	Төрийн бүх байгууллага Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залах.	Байгууллагынхаа удирдалагын өрөө тасалгаанд “Эзэн Чингис” хааны эш хөрөг зургийг залж дээдлэн хүндлэж байна. Үр нөлөө:Эзэн богд Чингис хааны эш хөргийг залж албан хаагчдад эерэг сэтгэл зүйг төлөвшүүлэхэд нэмэр болсон.	100%		

	84		3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг иргэдэд уриалах.	Мөн 2023 оны 09 сард Шинжлэх ухааны үндэслэлтэй мал эмнэлгийн алба үүсч хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд эмч, мэргэжилтэн, байгууллагын ахмад, зочид зэрэг нийт 60 хүнд “Эзэн богд Чингис хаан”-ны эш хөргийг гарын бэлэг болгож өгсөн ба өрх гэр бүл гэртээ залж дээдлэн шүтэж байхыг тайлбарлан таниулсан. Үр нөлөө: Чингис хааны хөргийг 60 өрх гэрт бэлэглэж уриалсан.	100%			
ЗГ-ын тогтоол									
39	93	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн	- Төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; - төрийн байгууллагын шийдвэр, албан бичиг, дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; - төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; - төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 105 дугаар зарлиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Монгол бичгийн хэрэглээг олон нийтийн хүртээл болгож, хос бичигтэн болгох, үндэсний өв соёлоо хөгжүүлэх, “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан Монгол Улсын гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит “Монгол бичиг мину-XXI” говийн бүсийн олимпиад, Сүмбэр сумын ЗДТГ-аас зохион байгуулсан “Монгол бичигтэн 2025” тэмцээнд давхардсан тоогоор 11 албан хаагч амжилттай оролцсон. Тэмцээний үед албан хэрэг хөтлөлтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгсөн ба байгууллагын гадна, дотор хаягыг хос бичгээр, монгол бичгийн самбар байгуулсан. Хүмүүн бичиг сонинг захиалж албан хаагчдад нээлттэй танилцуулсан. Бичиг хэргийн үйл ажиллагаанд монгол бичгийн программ, хос бичгийг нэвтрүүлээд байна. Төрийн алба хаагчдын үндэсний бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх чиглэлээр хуваарьт багшийг 4 удаа урьж	70%			

			<p>албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.</p>		<p>давхардсан тоогоор 11 албан хаагч сургалтад хамрагдсан. Үр нөлөө: энэ оны сургалтад давхардсан тоогоор 11 албан хаагчийг хамруулж мэдлэгийг сайжруулсан.</p>			
--	--	--	--	--	---	--	--	--

40	94	<p>Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139</p>	<p>1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтыг олон улсын тэргүүлэх шинэ дэвшилтэт арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т болон Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>Алсын хараа 2050 богино хугацааны сургалтад төрийн албан хаагчдыг хамруулах.</p>	<p>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтад 3 албан хаагчийг хамруулж, сертификат гардан авсан ба дотоод сургалт хийж албан хаагчдыг бүрэн хамруулсан.</p> <p>Үр нөлөө: Байгууллагын 12 албан хаагч анхан шатны мэдлэгтэй болсон.</p>	100%		
----	----	---	--	---	--	------	--	--

41	95	<p>Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340</p>	<p>1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбоодттой хамтран зохион байгуулах.</p>	<p>Сумын Засаг дарга, Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хоорондын гурвалсан гэрээг жил бүр байгуулж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг 3, улсын төсвөөс санхүүжүүлдэг 6, малчид төлбөрийг хариуцдаг 2 нийт 11 төрлийн дархлаажуулалт мөн паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ болох тарилга, туулга, угаалга, боловсруулалтыг хувийн хэвшлийн нэгжээр гүйцэтгүүлж, технологийн мөрдөлтөнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажилладаг. Мал эмнэлгийн хавар, намрын технологит арга хэмжээг Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдад ажиллаж буй 6 МЭҮН-ээр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ба 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 391.7 мян.тол малыг мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулсан. Үр нөлөө:Мал эмнэлгийн захиалгат ажил үйлчилгээг 3 суманд ажиллаж буй 6 МЭҮН-ээр гүйцэтгүүлсэн ба гоц халдварт өвчнөөр тайван байдлыг 3 суманд хангасан.</p>	100%		
----	----	---	---	---	---	------	--	--

43	101	<p>Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419</p>	<p>3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./</p>	<p>- Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх. - Орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжин ажиллах.</p>	<p>Томилгоот 1 албан хаагчийг байгууллагад бүртгэлтэй орон сууцанд, 1 албан хаагчийг Сүмбэр сумын ЗДТГ-ын дэмжлэгээр түрээсийн байранд, 1 алба хаагчийг АЗДТГ-ын шийдвэрээр 1 өрөө түрээсийн байранд хамруулж, амьдрах орон байрны асуудлыг хамтран шийдвэрлэсэн. Үр нөлөө:МЭГ-т ажиллаж буй томилгоот 3 албан хаагчийн ажиллаж, амьдрах тогтвортой байдалд дэмжлэг үзүүлж, асуудлыг шийдвэрлэсэн.</p>	90%		
----	-----	--	--	--	--	-----	--	--

50	111	<p>Төрийн зарим тушаалын цалингийн доод шинэчлэн тухай 2023-06-21 Дугаар 2023_241</p> <p>албаны зарим албан тушаалын хэмжээ, хэмжээг тогтоох тухай</p>	<p>2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.</p>	<p>Цалингийн хэмжээ шинэчлэгдсэнтэй холбогдуулан өр авлага үүсгэлгүй ажиллах.</p>	<p>Байгууллагын 2024 оны нийт төсөв 738,419,200 төгрөг ба Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангасан ба төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр, авлагагүй ажилласан.</p> <p>Үр нөлөө: Нийт төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх талаар холбогдох арга хэмжээг сар бүр хэрэгжүүлж, өр авлагагүй ажилласан.</p>	100%		
53	114	<p>Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2023-07-19 Дугаар 2023_279</p>	<p>2. 2.5. Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>	<p>өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах.</p>	<p>ХХААХҮЯ-ны харъяа АДОБНЗ-наас төлөөлөл Малах отрын бүсийн орон тооны бус зөвлөлийг хуралдуулсан ба уг хурлаар дараах шийдвэрийг гаргав. Үүнд: Тусгай хэрэгцээний газарт зөвхөн цаг хүндэрсэн нөхцөлд хонин толгойд шилжүүлснээр Говьсүмбэр аймгаас 114.0 мян.тол мал, Төв аймгаас 15.0 мян.тол мал, Дундговь аймгаас 15.0 мян.тол малыг өвөлжүүлж, хаваржуулахаар шийдвэрлэсэн. 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар Малах отрын бүс нутагт Говьсүмбэр аймгийн 114.0 толгой мал өвөлжиж байгаа ба бусад орон нутгаас отор нүүдлийн шилжилт хөдөлгөөн хийгдээгүй байна.</p> <p>Үр нөлөө: Малах АДОБН дахь 68 малчин өрхөд болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар зөвөлгөө өгсөн.</p>	100%		

70	135	<p>Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_62</p>	<p>2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай. (1.Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.)</p>	<p>Шуурхай штабд үүрэг гүйцэтгэж холбогдох мэргэжлийн хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p>	<p>Аймгийн онцгой комиссын даргын 2024 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн “Ажлын хэсэг томилох тухай” 02 дугаар тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, ХХААГ болон бусад байгууллагын удирдах албан тушаалтнуудаас бүрдсэн онцгой комиссын штабад хуваарийн дагуу 24 цагаар үүрэг гүйцэтгэж ажилласан ба 05 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайланг нэгтгэн ОБГ-т хүргүүлсэн.</p> <p>Үр нөлөө: АОБГ, АОК-оос өгсөн чиг үүргийн дагуу ажиллаж үүрэг даалгаврыг тухай бүр бүрэн биелүүлсэн.</p>	100%		
----	-----	---	---	--	---	------	--	--

	136		<p>3.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: 3.1. Мал аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдал, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор “Малчдадаа тусалъя аян”-ыг үндэсний хэмжээнд зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>	<p>Малчдад мэргэжлийн болон бусад тусламж дэмжлэгийг хүргэх арга хэмжээнд идэвхи санаачлагатай оролцох.</p>	<p>“Малчдадаа тусалъя” аяны хүрээнд дараах ажлыг зохион байгуулж ажилласан. Үүнд: 1.Сүмбэр сумын Засаг даргын тамгын газарт 460,000 төгрөг, ХХААХҮЯ-нд 654,850 төгрөг нийт 1,114,850 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлсэн. 2. Малчны хотонд хүргэх тусламжийн өвс, тэжээл ачих ажилд 3 удаа оролцсон ба 3 автомашинд нийт 1000 гаруй боодол өвсийг зөвхөн хамт олны хүчээр ачиж хөдөлгөсөн. 3.Сүмбэр сумын 4, 5, 6 дугаар багт ажиллах 4 ажлын хэсэгт Мал эмнэлгийн газар, үйлчилгээний нэгжээс 4 малын эмч оролцон нийт 114 малчин өрхөд очиж мал эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн. Тус арга хэмжээний хүрээнд зөвхөн хээлтэй малд зориулсан нэг бүр нь 30,000 төгрөгийн үнэ бүхий 40ш тусламжийн багцийг 40 өрхөд гардуулж өгсөн. Нийт 108 толгой малд анхны тусламж үзүүлсэн. 4.Сүмбэр сумын ЗДТГ-аас хуваарилсан Малах багийн малчин Б.Дагвадоржийнд 2024 оны 03 сарын 14-ний өдөр очиж тусламж, дэмжлэг үзүүлсэн. Тус арга хэмжээнд байгууллагын 10 албан хаагч хамрагдаж хашаа хороог цэвэрлэж, цас мөсийг зөөж зайлуулсан. Мөн өрхийн хүнсний хэрэгцээнд зориулж нэг багц хүнсний бүтээгдэхүүн, малын тэжээлд зориулж 6 уут хивэг, малын амин дэмийн дутлыг нөхөх тарилгын бэлдмэл 2 ширхэгийг тус тус олгосон ба Е витамин, селений дутлыг нөхөх нэг удаагийн тунтай тарилгыг 144 малд тарьж биеийн</p>	100%		
--	-----	--	---	---	---	------	--	--

					<p>ерөнхий байдалд дэмжлэг үзүүлсэн. Тусламжийн зардалд нийт 437,000 төгрөг зарцуулсан.</p> <p>5.Дундговь аймгийн Баянжаргалан, Өндөршил суманд отроор хаваржиж буй малчин өрхөд тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилгоор Сүмбэр сумын ЗДТГ(1), Нэгдсэн эмнэлэг(1), Онцгой байдлын газар(1), Мал эмнэлгийн газрын(2) хамтарсан 5 хүний бүрэлдэхүүнтэй баг 2024 оны 03 сарын 19, 20-ны өдрүүдэд дээрх сумдад ажиллалаа. Тус арга хэмжээний хүрээнд Сүмбэр сумын харъяат 13 малчин өрхөд очиж өрх бүрт тусламжийн багц хүлээлгэн өгсөн ба 34 хүн, 14 малд анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн. Мөн малын эм, эмнэлгийн хэрэгслийн ганзагын худалдаа хийж, 5 төрлийн 10ш нийт 130,000 төгрөгийн эм, тэжээлийн нэмэлт бэлдмэл худалдан борлуулсан. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан 13 малчин өрхөд зөвлөгөө өгч 1 төрлийн 13ш гарын авлага олгов. Үр нөлөө:Хамтарсан болон бие даасан 7 төрлийн арга хэмжээнд хамтран оролцож малчид болон малд бодит дэмжлэг үзүүлсэн.</p>			
--	--	--	--	--	--	--	--	--

73	141	Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82	2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.)	Төрийн албан хаагчдад зохих хууль, эрх зүйн хүрээнд нийцүүлэн орон нутгийн нэмэгдэл олгох ажлыг зохион байгуулах.	Энэ оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 сарын байдлаар одоо ажиллаж байгаа 14 алба хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл 20-40 хувийг олгож байгаа ба нэмэгдэлтэй холбоотой хуулийн зохицуулалт, тушаал шийдвэр, тогтоолыг хүний нөөцийн системд бүртгэж баяжилтыг хийсэн. Үр нөлөө: Орон нутгийн нэмэгдэлд 14 албан хаагчийг сар бүр хамруулсан.	100%		
74	142	Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024-02-28 Дугаар 2024_83	3. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн	Мөнгөн урамшуулалд болзол хангасан албан хаагчдыг бүрэн хамруулах.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор 4 албан хаагчид 28,360,809 төгрөгийн урамшуулал олгосон. 2025 онд урамшуулал авах 1 алба хаагчийн хүсэлтийг төсөвт суулгаж өгөх талаар албан бичгийг ерөнхий газарт хүргүүлсэн. Үр нөлөө: Мал эмнэлгийн мэргэжлээр төрийн албанд тасралтгүй 5 жил ажилласан 4 төрийн албан хаагчид 6.7-8.5 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон.	100%		

			урамшуулал олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.)					
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл								
80	148	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	- Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх. - Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах.	Улсын хэмжээнд нэвтрүүлж буй тоон гарын үсгийг 2022 онд нэвтрүүлсэн ба байгууллагын 14 албан хаагч иргэний тоон гарын үсэг нээлгэсэн. Мөн байгууллагын удирдлага тоон гарын үсэг нээлгэж, шаардлагатай тохиолдолд хэрэглэж хэвшсэн. Мөн аймаг орон нутгаас байгууллагын мэдээллийг ашиглаж байгаа үйлдлийн системийн аюулгүй байдлтай холбоотойгоор зохион байгуулсан төрийн үйлчилгээний цахим системүүдийн танилцуулга, ERP, цахим аймгийн бодлогын барим бичгийг боловсруулах зөвлөх үйлчилгээ", "Digital first1", ICP мэдээллийн аюулгүй байдлын тухай" сургалтад 1 алба хаагчийг тус тус хамруулсан.Тус байгууллага нь дотооддоо ERP, office.mahis.gov.mn (динамик) гэх мэт программуудыг үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн. Үр нөлөө:Байгууллагын удирдлага болон бүх албан хаагчид тоон гарын үсэг нээлгэж шаардлагатай тухай бүр ашиглаж хэвшсэн.	100%		
85	153	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.5. Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүнгийн талаар Хүнс, хөдөө аж	Отор нүүдлийн шилжилт, хөдөлгөөнийг мал эмнэлгийн үзлэгт хамрагдсан гарал	ХХААХҮЯ-ны харъяа АДОБНЗ-наас төлөөлөл Малах отрын бүсийн орон тооны бус зөвлөлийг хуралдуулсан ба уг хурлаар дараах шийдвэрийг гаргав. Үүнд: Тусгай	100%		

			<p>ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Отор нүүдлийн шилжилт, хөдөлгөөнийг мал эмнэлгийн үзлэгт хамрагдсан гарал үүслийн гэрчилгээг үндэслэх, тархвар зүйн асуумжийн дагуу зохион байгуулан ажиллах талаар аймаг, сумд хооронд гэрээ байгуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг бүх шатны Засаг дарга нарт;</p>	<p>үүслийн гэрчилгээг үндэслэх, аймаг, сумд хооронд гэрээ байгуулан ажиллах.</p>	<p>хэрэгцээний газарт зөвхөн цаг хүндэрсэн нөхцөлд хонин толгойд шилжүүлснээр Говьсүмбэр аймгаас 114.0 мян.тол мал, Төв аймгаас 15.0 мян.тол мал, Дундговь аймгаас 15.0 мян.тол малыг өвөлжүүлж, хаваржуулахаар шийдвэрлэсэн. 2024 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар Малах АДОБН-т өвөлжиж буй 68 өрхтэй 2 МЭҮН гэрээ байгуулан малын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна. Үр нөлөө:Малах АДОБН-т өвөлжиж буй 68 өрхийг 2 МЭҮН-тэй гэрээжүүлсэн.</p>			
154			<p>XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;</p>	<p>төрийн байгууллагын цахим удирдлагын ERP системийг бүрэн ашиглах, албаны цахим хаягийг албан хэрэгт ашиглах</p>	<p>Тус байгууллага нь дотооддоо ERP, office.mahis.gov.mn (динамик) гэх мэт программуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа ба төрийн байгуулагуудтай баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож байдал хэвшсэн. Үр нөлөө: Байгууллагад хэрэглэгдэх 11-15 төрлийн цахим хэрэглээг хэвшүүлсэн ба хэмнэлт бий болгосон.</p>	100%		

90	159	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11	XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.	Жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	Байгууллагын батлагдсан орон тоо 21, байхаас 14, үүнээс эрэгтэй 6, эмэгтэй 8 байна. Дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу эмэгтэй албан хаагчдад зориулсан сургалтыг 1 удаа зохион байгуулж, бүрэн хамруулсан. Мөн нийт албан хаагчдыг хамруулсан 1 удаагийн дотоод сургалтыг зохион байгуулж жендэр, жендэрийн тухай хуулийн мэдлэг, эрэгтэй, эмэгтэй албан хаагчдын үүрэг оролцоо, идэвхи санаачлагыг сайжруулахад чиглэсэн зөвлөн туслах сургалтад хамруулсан. Үр нөлөө:Бүх албан хаагчид жендэрийн эрх тэгш байдлын талаар мэдлэгтэй болсон.	100%		
95	165	2023 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2023-05-24 Дугаар 2023_22	XXI.5.3. Гамшгийн улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах, устгах ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав.	малын сэг, зэм булшлах, устгах ажлыг зохион байгуулах.	Мал аж ахуйн 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал, “Зудын гамшиг”-ийн улмаас хорогдсон мал, амьтны сэг зэмийг булж устгах үйл ажиллагааг 02 дугаар сараас эхлэн Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдад амжилттай зохион байгуулж, 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 93.3%-ийн гүйцэтгэлтэй дууссан. Сэг зэм устгалд аймгийн хэмжээнд нийт 111551ш сэг зэмийг устгалын 18 цэгт булшилж, устгасан ба сэг зэм устгах ажилд давхардсан тоогоор 141 автомашин, 256 хүн ажиллаж, 5200м ² талбайг ариутган 571кг халдваргүйтгэлийн бодис зарцуулж, 154.3 сая төгрөг зарцуулсан байна. Сэг зэм устгалын арга хэмжээг Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын ЗДТГ, ОБГ, ЦХ, ТХ, МЭГ, БОАЖГ хамтран зохион байгуулсан ба үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг аймгийн шуурхай штаб, улсын	100%		

			<p>мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.</p>					
100	175	<p>2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40 дүгээр тэмдэглэл 2023-10-04 Дугаар 2023_40</p>	<p>2.22. Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг мал эмнэлгийн ажил, үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэх асуудлыг судалж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засагдарга нарт;</p>	<p>Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг мал эмнэлгийн ажил, үйлчилгээний үнэ тарифыг мөрдөн ажиллах.</p>	<p>Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/116,А/418 дугаартай хамтарсан тушаалаар улсын хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний (норматив) зардлыг бод-1000, бог-350, амьтан- (гахай, нохой, муур) 1000, (шувуу) 350 төгрөг байхаар тогтоосныг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд болон малчдын группт түгээж мэдээлсэн. 2024 онд мал эмнэлгийн ажил үйлчилгээнд улсын төсвийн 93.7 сая төг, орон нутгийн төсвийн 15.4 сая төгрөгийг тус тус тусган батлуулснаар орон нутгийн төсвөөс 15.4 сая төгрөгөөр 3 нэр төрлийн вакцин авсан. Мал эмнэлгийн захиалгат ажил үйлчилгээний хөлсөнд 2024 оны 10 сарын 30-ны өдрийн байдлаар улсын төсвөөс 11,372,000 төгрөг, орон нутгийн төсвөөс 14,015,500 төгрөг олгосон.</p> <p>Үр нөлөө: Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/116,А/418 дугаартай хамтарсан тушаалыг мал эмнэлгийн ажил үйлчилгээний хөлсөнд мөрдөж ажилласан.</p>	100%		

104	183	<p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл 2023-12-20 Дугаар 2023_51</p>	<p>XXV.4.3. Орон нутгийн иргэдийн эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав</p>	<p>Иргэдийн эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх.</p>	<p>Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэгт 12 алба хаагч хамрагдсан ба шинээр томилогдсон 2 алба хаагчийг нөхөж хамруулахаар төлөвлөөд байна. Аймгийн эрүүл мэндийн газартай хамтран “Эрүүл зөв хоололт” сэдвээр сургалт зохион байгуулж, сургалтад хамрагдсан 10 албан хаагчийн биеийн ерөнхий индкесийг тодорхойлуулж, цусны шинжилгээ өгсөн. Мөн хамтын ажиллагааны хүрээнд 6 албан хаагч цус сэлбэх төвд цусаа бэлэглэсэн. Үр нөлөө:12 албан хаагчийг эрт илрүүлэгт хамруулж, 4 албан хаагч өдрийн эмчилгээнд хамрагдаж эрүүл мэндийн ерөнхий байдлыг дээшлүүлсэн.</p>	100%		
107	191	<p>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 8 дугаар тэмдэглэл 2024-02-28 Дугаар 2024_8</p>	<p>22.6.2. Зудын улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах, устгах ажлыг өргөн хүрээтэй, шуурхай зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав.</p>	<p>Хорогдсон малын сэг зэм устгалыг шуурхай зохион байгуулах</p>	<p>Мал аж ахуйн 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал, зудын гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны сэг зэмийг булж устгах үйл ажиллагааг 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Сүмбэр, Баянтал, Шивээговь суманд зохион байгуулж, 04 дүгээр сарын 26-ны өдөр 93.3%-ийн гүйцэтгэлтэй дууссан. Уг арга хэмжээнд нийт 111551ш сэг зэмийг устгалын 18 цэгт булж устгасан. Үүнд давхардсан тоогоор 141 автомашин, 256 хүн ажиллаж, нийт 5200м² талбайг халдваргүйжүүлж, 571кг халдваргүйтгэлийн бодис ашигласан ба үйл ажиллагааны зардалд 154,3 сая төгрөг зарцуулсан. Мөн мал эмнэлэг, ариун цэврийн төлөвлөгөөт халдваргүйтгэлд МАА-н 52 цэгийн 36729м² талбайг хамруулсан ба 05 сарын 23-ны өдрийн байдлаар нийт 41929м² талбайг халдваргүйжүүлж, гүйцэтгэл 95%. Сэг зэм устгал, халдваргүйтгэлийн</p>	100%		

					<p>үйл ажиллагаанд тавих хяналтыг 33 удаа хэрэгжүүлсэн ба зөвлөмж арга зүйг урьдчилсан байдлаар болон газар дээр нь өгч ажилласны үр дүнд зөрчил дутагдал илрээгүй. Үр нөлөө:Зудын гамшгийн улмаас хорогдсон малын сэг зэмийг 02 сарын 10-ны өдрөөс 04 сарын 26-ны өдөр хүртэл шуурхай зохион байгуулж, 115,551 сэг зэм булж устгасан ба 5200м2 талбайг халдваргүйжүүлсэн.</p>			
	192		<p>22.10.3. Орон нутгийн хэмжээнд бэлтгэсэн махны чанар, аюулгүй байдалд хяналт, шалгалт хийх, стандартын шаардлага хангасан махыг төв, суурин газрын хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт</p>	<p>махны чанар аюулгүй байдалд хяналт тавих</p>	<p>Сүмбэр, Шивээговь сумдад мах бэлтгэж буй мал нядалгааны 5 цэгт давхардсан тоогоор 11 удаа хяналт, шалгалт явуулж, 4 иргэний мал төхөөрөх цэгийн үйл ажиллагааг түр зогсоож, Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авч 1,000,000 төгрөгийн торгууль ногдуулж, мал эмнэлэг ариун цэврийн шаардлагыг сайжруулсан. Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтарч 2023-2024 онд хүн амын махны хэрэгцээнд зориулж мах нөөцөлсөн 8 иргэн, ААН-ийн 106тн махны хадгалалт болон худалдаалалтын явцад мал эмнэлэг, ариун цэврийн эрүүл ахуйн шаардлагыг хангуулах чиглэлээр хяналт, шалгалт хийн, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн ба 1 ААН-д 8 заалт бүхий хугацаатай албан шаардлага өгч хэрэгжилтийг хангуулсан. Үр нөлөө: Махны эрүүл, аюулгүй байдал, хадгалалт, хамгаалалт, орчны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдал зэргийг үзэж 8 төрлийн зөрчил дутагдал илэрснийг газар дээр нь арилгуулж, зөвлөмж арга зүйгээр хангаж ажилласан.</p>	100%		

111	197	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6	1. 1.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах;	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх сургалтад албан хаагчдыг хамруулах, иргэдэд сурталчилах ажлыг зохион байгуулах.	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Гэээгт ЗБН-өөс махны бизнес эрхлэгчдэд зориулан зохион байгуулсан "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт", "Үйлдвэр цехийн стандарт" сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт оролцож "Төхөөрөх мал, амьтанд үзлэг хийх, бүртгэл хөтлөх, хяналт тавих шаардлага ач холбогдол, мал эмнэлгийн нэгдсэн цахим систем, гэрчилгээ олголт"-ын талаар мэдээлэл хүргэж, мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Уг арга хэмжээнд 121 хүн хамрагдсан.	70%		
112	200		1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэх.	Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, төрийн үйлчилгээг цахимжуулах талаар жил бүр ажил зохион байгуулж хэвшсэн ба 2024 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 44 ажил, арга хэмжээний мэдээ, мэдээллийг Мал эмнэлгийн газрын цахим хуудас, пейж хуудсанд байршуулсан. Мөн мал, малаас гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнд олгох мал эмнэлгийн гэрчилгээ олголтыг цахимжуулсан ба мал эмнэлгийн газар, тасаг, нэгжийн эмч нар ашиглаж хэвшсэн. Энэ нь гарал үүслийг тодорхойлох, мөрдөн мөшгих тогтолцоог хэрэгжүүлэх, малын хулгайг	100%		

					илрүүлэх үр дүнтэй ажил болж чадсан. Үр нөлөө:Зорилтот бүлэгт мэдээллийг цахим хэлбэрээр түгээж хэвшсэн.			
113	201	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай 2023-07-25 Дугаар 2023_03	2.. 2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 2.1. Нутаг дэвсгэрийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө, захирамж, удирдамж гарган хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах; 2.2. Нийт мал сүрэгт үзлэг ангилалтын ажлыг технологийн дагуу хийж, стандартын шаардлага хангахгүй үржлийн малын 10 хүртэлх, дундаас доош тарга хүчтэй, эр сувай малын 50 хүртэлх хувийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах; 2.3. Хээлтүүлэгчийн үзлэг ангилалт, заазлалтыг чанартай гүйцэтгүүлэх, дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн тавих, хээлтүүлгийн ажлыг технологийн хугацаанд хийж хэрэгжүүлэх; 2.4. Мал, эмнэлгийн үйлчилгээг шуурхай, чанартай зохион байгуулах, хот суурин газарт нэвтрэх мал, мах, малын гаралтай түүхий эд,	- Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах. - Мал сүрэгт үзлэг ангилалтын ажлыг технологийн дагуу хийж, стандартын шаардлага хангахгүй үржлийн малын 10 хүртэлх, дундаас доош тарга хүчтэй, эр сувай малын 50 хүртэлх хувийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах. - Хээлтүүлэгчийн үзлэг ангилалт, заазлалтыг чанартай гүйцэтгүүлэх, дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн тавих, хээлтүүлгийн ажлыг технологийн хугацаанд хийж хэрэгжүүлэх.	МАА-н 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын гүйцэтгэл 93.3%, 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын гүйцэтгэл 98.5%. Үр дүн:Давхардсан тоогоор 391585 толгой малыг халдварт, паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд, МАА-н 68065м2 талбайг халдваргүйтгэлд, 13766толгой мэдрэмтгий малыг эрт илрүүлгийн үзлэгт хамруулсан.	100%		

		<p>бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгохдоо вакцинжуулалт, тарилга, туулгалтын хугацааг сайтар хянах, тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, зам дагуу байрлах орон нутгийн чанартай хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх;</p> <p>2.5. Хадлангийн талбайг оновчтой хуваарилах, зохистой ашиглах, говийн бүсийн болон хадлангийн нөөц багатай аймгуудад хадлан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд нь хийж гүйцэтгэх;</p> <p>2.6. Ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлэн байдал, зохион байгуулалтыг бүрэн хангуулах, цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах;</p> <p>2.7. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж орлого бүрдүүлэлтийг ил тод болгох, орлогын эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрэмбэлэн зарцуулах, хяналт тавих;</p> <p>2.8. Бэлчээрийн даац,</p>					
--	--	--	--	--	--	--	--

			<p>багтаамжид тулгуурлан аймаг, сум дундын отрын бүс нутаг, улсын хилийн зурвас болон байгалийн тусгай хамгаалалттай газар нутагт отроор өвөлжүүлэх малчин өрх, мал сүргийн тоог харилцан тохиролцож гэрээ байгуулан ажиллах, бүс алгасаж отор нүүдэл хийхгүй байхад анхаарах; 2.9. Отроор нүүдэллэж байгаа малчин өрхийг тухайн нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээ үзүүлж ажиллах; 2.10. Орон нутгийн тусгай хэрэгцээний газарт отор нүүдэл хийх журмыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж, мөрдөн ажиллах;</p>						
--	--	--	--	--	--	--	--	--	--

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ДҮН

	Бүгд	Үүнээс										
		Монгол Улсын хууль	УИХ-ын тогтоол	Улсын их хурлын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан Даалгавар	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын тушаал
Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	27	3		1	3			9		10	3	

